

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН
2014 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2015.02.09

Улаанбаатар хот

НЭГ. ББСБ-ЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2014 онд 120 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, 5 ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг бүхэлд нь хүчингүй болгосноор тайлант хугацааны эцэст нийт 378 ББСБ Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байна.

2006 оны жилийн эцсийн тайлант хугацаанаас хойш ББСБ-уудын тоонд дараах өөрчлөлт орсон байна.

/Хүснэгт 1/

№	Тайлант хугацаа	Тайлант хугацааны эцэс дэх ББСБ-ын тоо	Үүнээс:		
			Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ	Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ	Зөвхөн гадаад валютын арилжаа эрхэлж буй ББСБ
1	2006 он	139	-	-	-
2	2007 он	137	-	-	-
3	2008 он	132	23	11	-
4	2009 он	177	27	9	47
5	2010 он	182	26	15	48
6	2011 он	195	23	17	39
7	2012 он	212	24	17	38
8	2013 он	263	31	19	41
9	2014 он	378	40	23	53

Хорооны хуралдаанаар тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын асуудлуудыг хэрхэн шийдвэрлэсэн байдлыг хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт 2/

№	Тайлант хугацаа	Тусгай зөвшөөрөл шинээр олгосон	Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон	Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн	Тусгай зөвшөөрлийг сэргээсэн	Тайлант хугацааны эцэс дэх ББСБ-ын тоо
1	2006 он	2	24	-	-	139
2	2007 он	10	12	-	-	137
3	2008 он	10	15	-	-	132
4	2009 он	56	11	15	9	177
5	2010 он	20	15	20	7	182
6	2011 он	32	19	14	8	195
7	2012 он	23	6	4	2	212
8	2013 он	54	3	3	1	263
9	2014 онд	120	5	5	1	378

2014 онд 120 компанид нийт 42,743,350.6 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгосон бөгөөд эдгээрээс 14.2 хувь нь буюу 17 компани нь зөвхөн гадаад валютын арилжааны үйл ажиллагааг дангаар эрхлэхээр, 85.8 хувь нь буюу 103 компани нь зээл, гадаад валютын


арилжаа, хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх, факторингийн үйлчилгээ эрхлэхээр банк бус санхүүгийн тусгай зөвшөөрөл авсан байна.

Тайлант хугацаанд Төв аймагт 3, Сэлэнгэ аймагт 2, Орхон аймагт 2, Дархан-Уул аймагт 2, Булган аймагт 1, Өмнөговь аймагт 1, Ховд аймагт 1 ББСБ буюу орон нутагт нийт 12 ББСБ 20.0-200.0 сая төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр, Улаанбаатар хотод 108 ББСБ 100.0-1,000.0 сая төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр зээл, гадаад валютын арилжаа, факторинг, хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх, төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авсан байна.

2014 оны тайлант хугацаанд Хорооны хуралдаанаар 5 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, 1 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг сэргээж, 5 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг бүхэлд нь хүчингүй болгон, 12 ББСБ-д тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны төрлийг нэмж олгосон.

Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ын тооны өөрчлөлтийг графикаар үзүүлбэл:

/График 1/



ББСБ-уудыг Монгол Улсын Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан үйл ажиллагаа, үйлчилгээ эрхэлж буйгаар нь ангилвал:

/Хүснэгт 3/

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо /давхардсан тоогоор/			
		2013 оны IV улирал		2014 оны IV улирал	
		тоо	хувь	тоо	хувь
1	Гадаад валютын арилжаа эрхэлдэг нийт	104	39.5	129	34.1
	Үүнээс: зөвхөн гадаад валютын арилжааг дагнан эрхэлдэг	41	15.6	53	14.0
2	Зээл	219	83.3	323	85.4
3	Факторингийн үйлчилгээ	13	4.9	16	4.2
4	Төлбөрийн баталгаа гаргах	9	3.4	11	2.9
5	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	0	0.0	0	0.0
6	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	5	1.9	6	1.6
7	Итгэлцлийн үйлчилгээ	21	8.0	24	6.3
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	2	0.8	2	0.5
9	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	21	8.0	29	7.7
10	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	0	0.0	0	0.0

2014 оны жилийн эцсийн байдлаар 378 ББСБ-ын 85.4 хувь нь зээл, 34.1 хувь нь гадаад валютын арилжаа /14.0 хувь нь гадаад валютын арилжааг дагнан эрхэлдэг/, 7.7 хувь нь хөрөнгө

оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх, 1.6 хувь нь цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, 4.2 хувь нь факторингийн үйлчилгээ, 2.9 хувь нь төлбөрийн баталгаа гаргах, 6.6 хувь нь итгэлцлийн үйлчилгээ, 0.5 хувь нь богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээг тус тус эрхлэн явуулж байна.

ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ

2.1. Ерөнхий статистик үзүүлэлтүүд:

Өмнөх оны мөн үеийн голлох статистик үзүүлэлтүүдийг 2014 оны жилийн эцсийн тайлант хугацаатай харьцуулж харуулбал:

/Хүснэгт 4/

№	Үндсэн үзүүлэлтүүд	2013 оны IY улирал	2014 оны IV улирал	Өсөлт /+/, бууралт -/
1	ББСБ-ын тоо	263	378	115
2	Хувьцаа эзэмшигчдийн тоо	762	868	106
3	Ажиллагсадын тоо	1,396	1,678	282
4	Салбар нэгжийн тоо	84	92	8
5	Харилцагчдын тоо	533,016	663,098	130,082
6	Нийт актив /мянган төгрөгөөр/	381,130,752.7	507,965,683.9	126,834,931.2
	<i>Банкны салбартай харьцуулахад /хувь/</i>	<i>1.82%</i>	<i>2.25%</i>	<i>0.43%</i>
7	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	223,711,713.9	303,132,859.4	79,421,145.5
	<i>Банкны салбартай харьцуулахад /хувь/</i>	<i>2.06%</i>	<i>2.44%</i>	<i>0.38%</i>
8	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	234,337,952.6	332,077,845.7	97,739,893.1
	<i>Банкны салбартай харьцуулахад /хувь/</i>	<i>17.70%</i>	<i>15.56%</i>	<i>-2.18%</i>
9	Нийт хувьцаат капитал /мянган төгрөгөөр/	183,691,627.8	258,197,982.6	74,506,354.8
	<i>Банкны салбартай харьцуулахад /хувь/</i>	<i>50.59%</i>	<i>65.56%</i>	<i>8.11%</i>
10	Итгэлцлийн үйлчилгээний өглөг /мянган төгрөгөөр/	19,074,014.6	25,659,100.7	6,585,086.1
11	Банк, банк бус санхүүгийн байгууллагаас татсан зээл /мянган төгрөгөөр/	90,226,226.1	123,584,216.7	33,357,990.6
	Үүнээс: Богино хугацаат зээл /мянган төгрөгөөр/	63,470,381.0	60,276,951.3	(3,193,429.7)
	Урт хугацаат зээл /мянган төгрөгөөр/	26,755,845.1	63,307,265.5	36,551,420.4
12	Төслийн зээлийн санхүүжилт /мянган төгрөгөөр/	11,917,167.1	12,502,932.8	585,765.7
13	Нийт орлого /мянган төгрөгөөр/	106,652,086.0	132,909,005.8	26,256,919.8
14	Нийт зардал /мянган төгрөгөөр/	76,817,416.7	96,548,372.7	19,730,956.0
15	Тайлант үеийн ашиг /мянган төгрөгөөр/	29,834,669.3	36,360,633.1	6,525,963.8

2014 оны жилийн эцсийн байдлаар 378 ББСБ нь 508.0 тэрбум төгрөгийн актив хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа явуулж байгаа ба активын өсөлт нь 2013 оны жилийн эцсээс 33.3 хувиар өссөн бөгөөд энэхүү өсөлтийн 58.7 хувийг хувь нийлүүлсэн хөрөнгө 74.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь дийлэнхи хувийг эзэлж байна. Тухайлбал, тайлант хугацаанд нийт 42.7 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 120 ББСБ шинээр тусгай зөвшөөрөл авсан, тайлант хугацаанаас өмнө тусгай зөвшөөрөлтэй байсан ББСБ-ууд нийт 31.8 тэрбум төгрөгөөр

хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтэцдээ өөрчлөлт оруулсан буюу нэмэлт хөрөнгө оруулалт, хуримтлагдсан ашгаар нэмэгдүүлжээ.

Тайлант хугацаанд ББСБ-уудын нийт актив 508.0 тэрбум төгрөг, зээлийн өрийн үлдэгдэл 303.1 тэрбум төгрөг, эзэмшигчдийн өмч 332.1 тэрбум төгрөг, хувьцаат капитал 258.2 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын үзүүлэлтүүдтэй харьцуулахад нийт активын 2.2 хувьтай, зээлийн өрийн үлдэгдлийн 2.4 хувьтай, эзэмшигчдийн өмчийн 15.6 хувьтай, хувьцаат капиталын 65.6 хувьтай тус тус тэнцэж байна.

ББСБ-д ажиллах боловсон хүчний тоо 1,678 /үүнээс эмэгтэй ажилчид 932/, харилцагчдын тоо 663,098–д хүрсэн байна. Харилцагчдын тооны бүтцийг авч үзвэл зээлдэгч 62882, факторингийн үйлчилгээнд хамрагдагсад 5, итгэлцлийн үйлчилгээнд 11331, төлбөр тооцооны болон бусад үйлчилгээнд 588880 үйлчлүүлэгч, харилцагчид тус тус хамрагдсан байна.

2014 оны жилийн эцсийн байдлаар Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрөлтэй 378 ББСБ байгаагийн 89.4 хувь буюу 338 ББСБ нь УБ хотод, 10.6 хувь буюу 40 ББСБ нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

ББСБ-уудын байршлыг графикаар үзүүлбэл:

/График 2/



Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 338 ББСБ-ын байршлыг авч үзвэл Чингэлтэй дүүрэгт 125, Баянзүрх дүүрэгт 44, Сүхбаатар дүүрэгт 101, Баянгол дүүрэгт 49, Хан-Уул дүүрэгт 15, Налайх дүүрэгт 2, Багануур дүүрэгт 2 ББСБ тус тус байрлан үйл ажиллагаа явуулж байна.

2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ:

2014 оны жилийн эцсийн байдлаар орон нутагт төвтэй 40 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 10.6 хувийг, тэдгээрийн актив нь нийт ББСБ-ын активын 2.2 хувийг, эзэмшигчдийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчдийн өмчийн 2.9 хувийг, хувь нийлүүлсэн хөрөнгө нь нийт ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн 2.6 хувийг тус тус эзэлж байна.

/Хүснэгт 5/

№	Үндсэн үзүүлэлтүүд	2013 оны жилийн эцэс	2014 оны жилийн эцэс	Өсөлт +/-, бууралт -/
	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	31	40	9

ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь		11.79%	10.58%	-1.2%
1	Нийт актив /мянган төгрөгөөр/	7,290,763.8	11,227,752.5	3,936,988.7
ББСБ-ын нийт активт эзлэх хувь		1.91%	2.21%	0.3%
2	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	5,563,418.6	8,766,732.6	3,203,314.0
	Үүнээс: Валютаар олгосон зээл /мянган төгрөгөөр/	-	-	-
ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь		2.49%	2.89%	0.4%
	Чанаргүй зээл /мянган төгрөгөөр/	155,111.4	184,151.7	29,040.30
3	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	6,946,731.2	9,673,465.5	2,726,734.30
ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь		2.96%	2.91%	-0.05%
4	Нийт хувьцаат капитал /мянган төгрөгөөр/	4,751,150.4	6,680,951.8	1,929,801.4
ББСБ-ын нийт хувьцаат капиталд эзлэх хувь		2.59%	2.59%	-
5	Банк, банк бус санхүүгийн байгууллагаас татсан зээл /мянган төгрөгөөр/	153,833.0	219,545.1	65,712.10
	Үүнээс: Богино хугацаат зээл /мянган төгрөгөөр/	100,000.0	78,665.6	-21,334.40
	Урт хугацаат зээл /мянган төгрөгөөр/	53,833.0	140,879.5	87,046.50
	Валютаар татсан зээл /мянган төгрөгөөр/		-	
6	Төслийн зээлийн санхүүжилт /мянган төгрөгөөр/	74,999.7	615,000.0	540,000.30
	Үүнээс: Валютаар /мянган төгрөгөөр/	-	-	-
7	Нийт орлого /мянган төгрөгөөр/	1,845,822.8	2,693,345.9	847,523.10
8	Нийт зардал /мянган төгрөгөөр/	869,434.1	1,198,491.7	329,057.60
9	Тайлант үеийн ашиг /мянган төгрөгөөр/	976,388.7	1,494,854.2	518,465.50

Хорооноос орон нутагт үйл ажиллагаа явуулж буй бичил санхүүгийн байгууллагуудын тоог нэмэгдүүлэх, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх талаар орон нутаг дахь төлөөлөгчдөд зориулсан сургалт, семинарыг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулж, иргэдэд чиглэсэн мэдээлэл, зөвлөгөөг бичил санхүүгийн газрын хянан шалгагч нар орон нутагт томилолтоор ажиллах хугацаандаа болон ажлын байранд, түүнчлэн телефон утсаар тухай бүрд нь заавар зөвлөмжийг өгч ажиллаж байгаагийн дүнд сүүлийн жилүүдэд орон нутагт үйл ажиллагаа явуулах ББСБ-ын тоо нэмэгдсээр байна.

Тухайлбал, 2012 оны жилийн эцэст 24 ББСБ орон нутагт үйл ажиллагаа явуулж байсан бол 2013 оны жилийн эцэст 31, 2014 оны жилийн эцэст 40 ББСБ орон нутагт үйл ажиллагаа явуулж тооны хувьд жил тутам 29 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Мөн УБ хотод төвтэй, үйл ажиллагаа явуулж буй 10 ББСБ нь хөдөө орон нутагт нийт 24 салбар нэгжийг байгуулан үйл ажиллагаа явуулж байна.

2.3 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ:

2014 оны жилийн эцсийн байдлаар гадаадын 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай 23 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 6.1 хувийг, тэдгээрийн нийт актив ББСБ-ын нийт активын 13.1 хувийг, олгосон зээл нь нийт ББСБ-уудын олгосон зээлийн 13.9 хувийг, эзэмшигчдийн өмч нь нийт ББСБ-уудын эзэмшигчдийн өмчийн 12.5 хувийг, хувь нийлүүлсэн хөрөнгө нь нийт ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн 13.0 хувийг тус тус эзэлж байна.

/Хүснэгт 6/

№	Үндсэн үзүүлэлтүүд	2013 оны жилийн эцэст	2014 оны жилийн эцэст	Өсөлт +/-, бууралт -/
	Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ын тоо	19	23	+4
ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь		7.22%	6.08%	-1.14%
1	Нийт актив /мянган төгрөгөөр/	51,084,405.1	66,757,988.4	15,673,583.3
ББСБ-ын нийт активт эзлэх хувь		13.40%	13.14%	-0.26%
2	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	33,411,560.2	42,034,697.3	8,623,137.1

	Үүнээс: Чанаргүй зээл /мянган төгрөгөөр/	2,079,200.1	2,748,267.5	669,067.4
	Валютаар олгосон зээл /мянган төгрөгөөр/	1,481,115.8	4,810,746.8	3,329,631.1
	<i>ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	<i>14.93%</i>	<i>13.87%</i>	<i>-1.06%</i>
3	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	33,952,471.0	41,614,522.9	7,662,051.9
	<i>ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь</i>	<i>14.49%</i>	<i>12.53%</i>	<i>-1.96%</i>
4	Нийт хувьцаат капитал /мянган төгрөгөөр/	25,700,362.5	33,491,829.4	7,791,466.9
	<i>ББСБ-ын нийт хувьцаат капиталд эзлэх хувь</i>	<i>14.00%</i>	<i>12.97%</i>	<i>-1.03%</i>
5	Банк, банк бус санхүүгийн байгууллагаас татсан зээл /мянган төгрөгөөр/	12,153,010.7	16,694,854.1	4,541,843.4
	Үүнээс: Богино хугацаат зээл /мянган төгрөгөөр/	6,863,131.2	7,280,689.4	417,558.2
	Урт хугацаат зээл /мянган төгрөгөөр/	5,289,879.6	9,414,164.7	4,124,285.1
	Валютаар татсан зээл /мянган төгрөгөөр/	1,654,100.0	2,205,690.6	551,590.6
Е	Төслийн зээлийн санхүүжилт /мянган төгрөгөөр/	1,005,000.0	4,451,200.0	3,446,200.0
	Үүнээс: Валютаар /мянган төгрөгөөр/	-	3,771,200.0	3,771,200.0
Ё	Нийт орлого /мянган төгрөгөөр/	15,086,690.0	15,319,600.54	232,910.5
Ж	Нийт зардал /мянган төгрөгөөр/	12,139,673.4	13,162,999.64	1,023,326.2
З	Тайлант үеийн ашиг /мянган төгрөгөөр/	2,947,016.7	2,156,600.9	-790,415.8

Гадаадын хөрөнгө оруулагчдыг харьяаллаар нь авч үзвэл Япон улсын хөрөнгө оруулалттай 10, БНСУ-ын хөрөнгө оруулалттай 6, АНУ 2, Итали, ОХУ, БНХАУ, Люксембург, Малайз, Швейцар, Хонгконгийн хөрөнгө оруулалттай тус бүр 1 ББСБ үйл ажиллагаа явуулж байна.

2.4 Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэн явуулж буй ББСБ:

Хорооноос тусгай зөвшөөрөлтэй нийт 378 ББСБ-ын 129 буюу 34.1 хувь нь гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгаагаас 53 нь зөвхөн гадаад валютын арилжааны үйл ажиллагааг дагнан эрхлэх зөвшөөрөлтэй байна.

Тайлант хугацаанд буюу 2014 оны жилийн эцсийн байдлаар нийт 120 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгосноос 18.3 хувь буюу 22 ББСБ-д банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон.

Тайлант хугацаанд гадаад валютын арилжааны үйл ажиллагааг давхар эрхлэн явуулж буй 124 ББСБ нь нийт ББСБ-ын 35.3 хувийг эзэлж байна.

Гадаад валютын арилжаа дангаар эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 53 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 14.0 хувийг, тэдгээрийн актив нийт ББСБ-ын активын 2.0 хувийг, эзэмшигчдийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчдийн өмчийн 2.0 хувийг, хувь нийлүүлсэн хөрөнгө нь нийт ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн 3.2 хувийг тус тус эзэлж байна. Гадаад валютын арилжааны үндсэн үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын санхүүгийн голлох үзүүлэлтүүдийг харуулвал дараах байдалтай байна.

/Хүснэгт 7/

№	Үндсэн үзүүлэлтүүд	2013 оны жилийн эцэст	2014 оны жилийн эцэст	Өсөлт +/-, бууралт -/
	Валютын арилжааны үндсэн үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	41	53	+12
	<i>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</i>	<i>15.59%</i>	<i>14.02%</i>	<i>-1.57%</i>
1	Нийт актив /мянган төгрөгөөр/	8,478,323.8	9,979,396.9	1,501,073.1
	<i>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</i>	<i>2.22%</i>	<i>1.97%</i>	<i>-0.25%</i>
2	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	8,323,756.7	9,921,734.4	1,597,977.7
	<i>ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь</i>	<i>3.55%</i>	<i>1.96%</i>	<i>1.59%</i>
3	Нийт хувьцаат капитал /мянган төгрөгөөр/	6,758,692.4	8,347,742.4	1,589,050.0

	ББСБ-ын нийт хувьцаат капиталд эзлэх хувь	3.68%	3.23%	-0.45%
4	Төслийн зээлийн санхүүжилт /мянган төгрөгөөр/	-	-	-
5	Нийт орлого /мянган төгрөгөөр/	1,477,994.5	1,452,307.8	-25,686.7
6	Нийт зардал /мянган төгрөгөөр/	1,140,176.3	1,381,507.7	241,331.4
7	Тайлант үеийн ашиг /мянган төгрөгөөр/	337,818.2	70,800.0	-267,018.2

ГУРАВ. АКТИВЫН БҮТЭЦ, ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1 Активын бүтэц, өөрчлөлт:

Тайлант жилд нийт ББСБ-уудын активын бүтэц өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад дараах байдалтай байна.

/Хүснэгт 8/

№	ХӨРӨНГӨ	2013.12.31		2014.12.31		Өөрчлөлт	
		Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь
A	Эргэлтийн хөрөнгө	368,558,057.8	96.7	490,509,716.3	96.6	121,951,658.5	33.1
1	Мөнгөн хөрөнгө	113,684,987.5	29.8	155,975,027.9	30.8	42,290,040.4	37.2
2	Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/	9,892,190.2	2.6	11,012,313.7	2.2	1,120,123.5	11.3
3	Нийт зээл	223,711,713.9	58.7	303,132,859.4	59.8	79,421,145.5	35.5
	(Зээлийн эрсдлийн сан)	6,411,883.8	1.7	15,171,481.7	3.0	8,759,597.9	136.6
4	Нийт санхүүгийн түрээсийн тооцооны авлага	-	-	-	-	-	-
	(Санхүүгийн түрээсийн эрсдлийн сан)	-	-	-	-	-	-
5	Нийт факторингийн тооцооны авлага	824,620.0	0.2	30,000.0	-	-794,620.0	-96.4
	(Факторингийн авлагын эрсдлийн сан)	1,500.0	0.0	7,500.0	0.01	6,000.0	400.0
6	Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	797,821.3	0.2	1,308,692.6	0.3	510,871.3	64.0
7	Бусад хөрөнгө	26,060,108.8	6.8	34,229,804.5	6.7	8,169,695.7	31.3
8	Санхүүгийн үүсмэл хэрэгсэл /дериватив/-ийн авлага	-	-	-	-	-	-
B	Эргэлтийн бус хөрөнгө	12,572,694.9	3.4	17,455,967.6	3.4	4,883,272.7	38.8
9	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө /цэврээр/	12,572,694.9	3.4	17,455,967.6	3.4	4,883,272.7	38.8
	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	16,391,865.1	4.4	22,237,577.3	4.4	5,845,712.2	35.7
	(Хуримтлагдсан элэгдэл)	3,819,170.2	1.0	4,781,609.7	0.9	962,439.5	25.2
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	381,130,752.7	100.0	507,965,683.9	100.0	126,834,931.2	33.3


2014 оны жилийн эцсийн байдлаар банк бус санхүүгийн тусгай зөвшөөрөлтэй 378 ББСБ нь 507,965,683.9 мянган төгрөгийн актив хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа явуулж байгаа ба активын өсөлт нь өмнөх оны мөн үеэс 126,834,931.2 мянган төгрөгөөр буюу 33.3 хувиар өссөн байна.

Активын өсөлтийг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна.

/График 3/



Тайлант хугацаанд нийт активын 96.6 хувь нь эргэлтийн хөрөнгө, 3.4 хувь нь эргэлтийн бус хөрөнгө байх ба өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна. /График 4/



Эргэлтийн хөрөнгийн 31.8 хувь буюу 155,975,027.9 мянган төгрөгийг мөнгөн хөрөнгө эзэлж байгаа ба мөнгөн хөрөнгийн 40.7 хувийг бэлэн мөнгө, 59.3 хувийн банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж эзэлж байна.

3.2 Зээлийн багцын чанар:

Зээлийн ангиллыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.

/Хүснэгт 9/

№	Ангилал	2013.12.31		2014.12.31		Өөрчлөлт	
		Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь
1	Хэвийн	205,075,622.1	91.7	263,054,675.6	86.8	57,979,053.5	28.3
	Үүнээс: 2014.8.27-ны өдрөөс үүссэн	-	-	76,452,960.5	25.2	-	-
2	Хугацаа хэтэрсэн	10,094,972.8	4.5	20,832,093.5	6.9	10,737,120.7	106.4
3	Чанаргүй зээл. Үүнээс	8,541,119.0	3.8	19,246,090.3	6.3	10,704,971.3	125.3
	Хэвийн бус	2,189,391.8	1.0	4,587,472.3	1.5	2,398,080.5	109.5
	Эргэлзээтэй	2,798,841.3	1.3	5,925,205.9	2.0	3,126,364.6	111.7
	Муу	3,552,885.9	1.6	8,733,412.1	2.9	5,180,526.2	145.8
	(Зээлийн эрсдлийн сан)	6,411,883.8	2.9	15,171,481.7	5.0	8,759,597.9	136.6
	Нийт зээл	223,711,713.9	100.0	303,132,859.4	100.0	79,421,145.5	35.5
	Үүнээс: Гадаад валютаар олгосон зээл	23,715,168.1	10.6	30,717,309.0	10.1	7,002,140.9	29.5


2014 оны жилийн эцсийн байдлаарх зээлийн үзүүлэлтийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нийт зээлийн хэмжээ 79,421,145.5 мянган төгрөгөөр буюу 35.5 хувиар нэмэгдсэн байх ба нийт зээлийн багцад эзлэх хугацаа хэтэрсэн зээл 1.1 дахин, чанаргүй зээлийн эзлэх хувь ББСБ-уудын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга

1.2 дахин өссөн байна. Зээлийн ангилал дахь чанаргүй зээлийн эзлэх хувь 1.1-с 1.4 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Тайлант хугацааны нийт зээлийн үлдэгдлийн 10.1 хувь буюу 30,717,309.0 мянган төгрөгийн зээлийг валютаар олгосон зээлийн үлдэгдэл эзэлж байгаа бөгөөд энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 29.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

ББСБ-уудын нийт зээлийн багцын бүтцийг өмнөх онуудтай харьцуулбал дараах байдалтай байна.

/График 5/



Тайлант хугацаанд 323 ББСБ нь банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааг бусад тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаатай хавсран эрхэлж байгаагаас 71.5 хувь нь буюу 231 компани нь зөвхөн зээлийн үйл ажиллагааг дагнан эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байна.

Нийт зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 323 ББСБ-уудаас 91.0 хувь нь буюу 294 нь зээлийн үйл ажиллагаа явуулж тэдгээрт 62,882 зээлдэгчийн 303,132,859.4 мянган төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй байгаагаас 19,246,090.3 мянган төгрөг буюу 6.3 хувийг чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл эзэлж байна.

Зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг ББСБ-уудаас зээл олголт, эргэн төлөлтийн тайланг 78.3 хувь нь буюу 253 ирүүлсэн бөгөөд дээрх тайланд хамрагдсан ББСБ-уудын хувьд тайлант хугацаанд 116,941.4 сая төгрөгийн зээл олгож, 29,175.7 сая төгрөгийн зээл эргэн төлөгдсөн байна.


Нийт олгосон зээлийн 90.4 хувийг иргэнд, 9.6 хувийг хуулийн этгээдэд олгосон байх ба үйл ажиллагааны зориулалтаар нь ангилан үзвэл 92.4 хувийг бизнесийн, 7.6 хувийг хэрэглээний зориулалтаар тус тус олгосон байна.

Судалгаанд хамрагдсан ББСБ-уудад тайлант жилд төлөгдсөн зээлийн 73.8 хувийг иргэдээс төлөгдсөн, 26.2 хувийг хуулийн этгээдээс төлөгдсөн зээл эзэлж байна. Төлөгдсөн зээлийг зориулалтаар нь ангилвал 75.1 хувийг бизнесийн, 24.9 хувийг хэрэглээний зээлийн төлөлт тус тус эзэлж байна.

Нийт олгосон зээлийн 3.4 хувийг барилгын салбарт, 1.2 хувийг уул уурхайн салбарт, 12.2 хувийг худалдаа үйлчилгээнд, 1.3 хувийг жижиг, дунд үйлдвэрлэлд, 1.0 хувийг цалинд, 0.4 хувийг орон сууц, 0.5 хувийг тээврийн хэрэгсэл худалдан авахад, 80.0 хувийг бусад зориулалтаар олгосон байна.

2014 оны жилийн эцсийн байдлаарх зээлийн чанарыг өмнөх онуудтай харьцуулахад нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь сүүлийн 3 жилийн дунджаас 2.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

/График 6/




3.3 Зээлийн хүү:

Тайлант хугацаанд нийт 378 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаагаас 85.4 хувь буюу 323 нь зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй бөгөөд тэдгээрийн 91.0 хувь буюу 294 нь зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа ба эдгээр компаниудын зээлийн сарын хамгийн дээд хүү 12.0 хувь, хамгийн бага хүү 0.3 хувь байна.

ББСБ-уудын зээлийн сарын дундаж дээд хүү 3.3 хувь, зээлийн дундаж доод хүү 1.8 хувь буюу нийт ББСБ-ын зээлийн сарын дундаж хүү 2.6 хувьтай байна.

ББСБ-ын зээлийн хүүг банкны зээлийн хүүтэй харьцуулбал дараах байдалтай байна.

/График 7/



3.4 Активын бусад үзүүлэлтийн талаар:

Тайлант хугацаанд богино хугацаат хөрөнгө оруулалтын дансны үлдэгдэлд 11,012,313.6 мянган төгрөг байх ба үүний 86.4 хувь нь буюу 9,518,929.3 мянган төгрөг нь арилжааны үнэт цаас, 13.6 хувь нь буюу 1,493,384.3 мянган төгрөг нь хөрөнгө оруулалтын үнэт цаас тус тус эзэлж байна.

/Хүснэгт 10/

№	Богино хугацаат хөрөнгө оруулалтын төрөл	Хэмжээ /мянган төгрөг/	Богино хугацаат хөрөнгө оруулалтад эзлэх хувь
1	Арилжааны үнэт цаас	9,518,929.3	86.4%
2	Хөрөнгө оруулалтын үнэт цаас	1,493,384.3	13.6%
3	Эрсдэлийн сан	-	-
	Нийт	11,012,313.6	100.0%

Факторингийн тооцооны авлагын 30,000.0 мянган төгрөг нь чанаргүй буюу хэвийн бус авлагад ангилагдан 7,500.0 мянган төгрөгийн эрсдэлийн сан үүсгэсэн байна.

Тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулж буй 378 ББСБ-д 22,237,577.3 мянган төгрөгийн үндсэн ба биет бус хөрөнгө бүртгэгдэн тэдгээрт 4,781,609.7 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэн тооцон нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн байна.

ДӨРӨВ. ПАССИВЫН БҮТЭЦ, ӨӨРЧЛӨЛТ

2014 оны тайлант хугацаанд ББСБ-уудын нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.


/Хүснэгт 11/

№	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	2013.12.31		2014.12.31		Өөрчлөлт	
		Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь
A	Өр төлбөр	124,331,440.4	32.6	164,620,997.1	32.4	40,289,556.7	32.4
1	Итгэлцлийн үйлчилгээний өглөг	19,074,014.6	5.0	25,659,100.7	5.1	6,585,086.1	34.5
2	Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	90,226,226.1	23.7	123,584,216.7	24.3	33,357,990.6	37.0
3	Бусад эх үүсвэр	1,879,032.6	0.5	1,889,346.9	0.4	10,314.3	0.5
	Зээлийн батлан даалтанд байршуулсан эх үүсвэр	0.0	-	82,646.2	0.02	82,646.2	100.0
	Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	1,879,032.6	0.5	1,805,168.3	0.4	-73,864.3	-3.9
	Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг	-	-	1,532.4	0.0	1,532.4	100.0
4	ББСБ-аас гаргасан өрийн бичиг	1,235,000.0	0.3	985,400.0	0.2	-249,600.0	-20.2
5	Төслийн зээлийн санхүүжилт	11,917,167.1	3.1	12,502,932.7	2.5	585,765.6	4.9
	Бусад өр төлбөр	22,461,359.7	5.9	11,266,841.1	2.2	-11,194,518.6	-49.8
6	Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	2,280,064.3	0.6	3,227,695.1	0.6	947,630.8	41.6
7	Бусад пассив	20,181,295.4	5.3	8,039,146.0	1.6	-12,142,149.4	-60.2
	Нийт өр төлбөр	146,792,800.1	38.5	175,887,838.2	34.6	29,095,038.1	19.8
B	Эзэмшигчдийн өмч	234,337,952.6	61.5	332,077,845.7	65.4	97,739,893.1	41.7
8	Хувьцаат капитал	183,691,627.9	48.2	258,197,982.6	50.8	74,506,354.7	40.6
9	Бусад өмч	7,181,079.0	27.0	7,202,941.7	1.4	21,862.7	0.3
10	Сангууд	173,557.3	0.0	255,717.7	0.1	82,160.4	47.3
11	Хуримтлагдсан ашиг/алдагдал	41,711,462.9	10.9	64,028,518.3	12.6	22,317,055.4	53.5
	Тайлант үеийн ашиг	29,834,669.3	7.8	36,360,633.1	7.2	6,525,963.8	21.9
12	Хоёрдогч өглөг /5 жилээс дээш хугацаатай/	1,580,225.6	0.4	2,392,685.5	0.5	812,459.9	51.4
	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	381,130,752.7	100.0	507,965,683.9	100.0	126,834,931.2	33.3

2014 оны жилийн эцсийн байдлаар нийт эх үүсвэрийн 34.6 хувийг нийт өр төлбөр, 65.4 хувийг эзэмшигчийн өмч эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт өр төлбөр 19.8 хувиар, эзэмшигчдийн өмч 41.7 хувиар тус тус өссөн байна.

ББСБ-уудын системийн нийт пассивын хэмжээг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна.

/График 8/




Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ББСБ-уудын дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл 37.0 хувиар, төслийн зээлийн санхүүжилт 4.9 хувиар тус тус өсч, бусад эх үүсвэр 49.8 хувиар буурсан байна.


Тайлант хугацаанд шинээр байгуулагдсан банк бус санхүүгийн байгууллагуудын тоо өмнөх онтой харьцуулахад 43.7 хувийн өсөлттэй байгаа бөгөөд иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх сонирхол нэмэгдсэнтэйгээр ББСБ-уудын тоо, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр өсөхөд голлох нөлөө үзүүлж байна.

ББСБ-уудын системийн нийт эх үүсвэрүүдийн голлох үзүүлэлтүүдийг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна.

/График 9/



/График 10/



Тайлант хугацаанд нийт 175,887,838.2 мянган төгрөгийн өр төлбөртэй байгаагийн 14.6 хувь нь итгэлцлийн үйлчилгээгээр татсан эх үүсвэр, 70.3 хувь нь гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг, 7.1 хувь нь төслийн зээлийн санхүүжилт, 1.8 хувийг хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг тус тус эзэлж байна.

Нийт өр төлбөрийн 42.4 хувь буюу 74,519,846.4 мянган төгрөгийн эх үүсвэр нь гадаад валютаар татан төвлөрүүлсэн өрийн үлдэгдэл байна.

2014 оны жилийн эцсийн байдлаар итгэлцлийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй 24 ББСБ байгаагаас нэр бүхий 19 ББСБ нь итгэлцлээр 25,659,100.7 мянган төгрөгийн хөрөнгө татан төвлөрүүлсэн байх ба итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ББСБ нь нийт ББСБ-ын 5.0 хувийг, тэдгээрийн нийт актив нь нийт ББСБ-ын активын 41.2 хувийг, эзэмшигчдийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчдийн өмчийн 30.9 хувийг тус тус эзэлж байна.

Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 6 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаагаас 2014 оны жилийн эцэст 1,805,168.3 мянган төгрөгийн цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг бүртгэгдсэн байна.

Тайлант хугацаанд Хорооны зөвшөөрөлтэйгөөр хаалттай өрийн бичиг бүртгүүлсэн 3 ББСБ байх ба тэдгээр нь 985,400.0 мянган төгрөгийн хаалттай өрийн бичгийг гаргасан байна.

2014 оны жилийн эцсийн байдлаар 2,392,685.5 мянган төгрөгийн хоёрдогч өглөг бүртгэгдсэн байна.

ТАВ. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГАА

ББСБ-уудын 2014 оны жилийн эцсийн байдлаар нийт орлого өмнөх оны мөн үеэс 24.6 хувиар өссөн ба дараах үндсэн бүтэцтэй байна.

/Хүснэгт 12/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2013.12.31		2014.12.31		Өөрчлөлт	
		Дүн /мянган төгрөг/	Хувь	Дүн /мянган төгрөг/	Хувь	Дүн /мянган төгрөг/	Хувь
1	ХҮҮГИЙН ОРЛОГО	66,088,468.2	62.0	89,860,191.3	67.6	155,948,659.5	36.0
	Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	63,343,211.3	59.4	86,932,735.1	65.4	150,275,946.4	37.2
	Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого	1,373,035.8	1.3	2,117,758.5	1.6	3,490,794.3	54.2
	Үнэт цаасны хүүгийн	-	-	-	-	-	-

	орлого						
	Бусад хүүгийн орлого	1,372,221.1	1.3	809,744.4	0.6	2,181,965.5	-41.0
2	ХҮҮГИЙН БУС ОРЛОГО	39,317,031.9	36.9	41,620,140.3	31.3	80,937,172.2	5.9
3	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	1,088,442.6	1.0	1,288,052.6	1.0	2,376,495.2	18.3
4	ЕРДИЙН БУС ОРЛОГО	158,143.3	0.1	88,334.6	0.1	246,477.9	-44.1
	НИЙТ ОРЛОГО	106,652,086.0	100.0	132,856,718.8	100.0	239,508,804.8	24.6

Тайлант хугацааны нийт орлогын 67.6 хувийг хүүгийн орлого /өмнөх оны нийт орлогод эзлэх хүүгийн орлогын дүнтэй харьцуулахад 36.0 хувиар өссөн/, 31.3 хувийг хүүгийн бус орлого /өмнөх оны нийт орлогод эзлэх хүүгийн бус орлогын дүнтэй харьцуулахад 5.9 хувиар өссөн/ эзэлж байна.

Хүүгийн бус орлого өмнөх оны мөн үеэс 5.9 хувиар өссөн ба дараах үндсэн бүтэцтэй байна.

/Хүснэгт 13/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2013.12.31		2014.12.31		Өөрчлөлт	
		Дүн /мянган төгрөг/	Хувь	Дүн /мянган төгрөг/	Хувь	Дүн /мянган төгрөг/	Хувь
1	Арилжааны орлого	4,863,768.3	12.4	4,083,921.3	9.8	-779,847.0	-16.0
1.1	Гадаад валютын арилжааны орлого	4,863,423.0	12.4	4,083,921.3	9.8	-779,501.7	-16.0
1.2	Үнэт цаасны арилжааны орлого	345.4	0.0	820.0	0.0	474.6	137.4
2	Ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого	28,615,644.5	72.8	29,934,236.1	71.8	1,318,591.6	4.6
2.1	Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	26,982,916.8	68.6	28,465,730.8	68.3	1,482,814.0	5.5
2.2	Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн орлого	1,632,727.7	4.2	1,468,505.3	3.5	-164,222.4	-10.1
3	Санхүүгийн үйлчилгээний орлого	5,837,619.1	14.8	7,654,267.8	18.4	1,816,648.7	31.1
3.1	Санхүүгийн түрээсийн орлого	16,089.4	0.0	1,051.6	0.0	-15,037.8	-93.5
3.2	Итгэлцлийн үйлчилгээний орлого	50	0.0	8,077.2	0.0	8,027.2	161.5 дахин
3.3	Мөнгөн гуйвуулгын орлого	733,005.1	1.9	865,215.3	2.1	132,210.2	18.0
3.4	Картын үйлчилгээний орлого	0	0.0	1,520.0	0.0	1,520.0	100.0
3.5	Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	752,097.1	1.9	720,531.4	1.7	-31,565.7	-4.2
3.6	Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	3,865,787.9	9.8	5,423,994.2	13.0	1,558,206.3	40.3
3.7	Бусад	470,589.6	1.2	633,878.2	1.5	163,288.6	34.7
	ХҮҮГИЙН БУС ОРЛОГО НИЙТ	39,317,031.9	100.0	41,672,425.3	100.0	2,355,393.4	6.0

2014 оны жилийн эцсийн байдлаар нийт хүүгийн бус орлогын 9.8 хувийг гадаад валютын арилжааны орлого, 71.8 хувийг ханшийн тэгшитгэлийн орлого, 18.4 хувийг бусад санхүүгийн үйлчилгээний орлого эзэлж байна.

Нийт зардлын бүтэц дараах байдалтай байна.

/Хүснэгт 14/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2013.12.31		2014.12.31		Өөрчлөлт	
		Дүн /мянган төгрөг/	Хувь	Дүн /мянган төгрөг/	Хувь	Дүн /мянган төгрөг/	Хувь
1	ХҮҮГИЙН ЗАРДАЛ	9,616,312.9	12.5	12,882,564.2	13.3	3,266,251.3	34.0
2	ХҮҮГИЙН БУС ЗАРДАЛ	58,845,644.9	76.6	66,731,273.9	69.1	7,885,629.0	13.4
3	БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН ЗАРДАЛ	3,384,446.2	4.4	11,380,864.1	11.8	7,996,417.9	2.4 дахин
4	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	1,224,643.3	1.6	1,006,121.1	1.0	-218,522.2	-17.8
5	ЕРДИЙН БУС ЗАРДАЛ	13,840.0	0.0	8,491.2	0.0	-5,348.9	-38.6
6	ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ	3,732,529.4	4.9	4,539,058.3	4.7	806,528.9	21.6
	НИЙТ ЗАРДАЛ	76,817,416.7	100.0	96,548,372.8	100.0	19,730,956.1	25.7

Тайлант хугацаанд нийт зардал өмнөх оны мөн үеэс 25.7 хувиар өссөнөөс хүүгийн зардал 34.0 хувиар, хүүгийн бус зардал 13.4 хувиар, болзошгүй эрсдэлийн зардал 2.4 дахин, орлогын татварын зардал 21.6 хувиар тус тус өсч харин үндсэн бус үйл ажиллагааны зардал 17.8 хувиар, ердийн бус зардал 38.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

2014 оны жилийн эцсийн байдлаар нийт орлого өмнөх оны мөн үеэс 24.6 хувиар, нийт зардал 25.7 хувиар өссөн байна.


Тайлант хугацаанд нийт 36,360,633.1 мянган төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 21.9 хувиар өссөн байна.

/Хүснэгт 15/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2013.12.31	2014.12.31	Өөрчлөлт	
		Дүн /мянган төгрөг/	Дүн /мянган төгрөг/	Дүн /мянган төгрөг/	Хувь
1	НИЙТ ОРЛОГО	106,652,086.0	132,909,005.8	26,256,919.8	24.6
2	НИЙТ ЗАРДАЛ	76,817,416.7	96,548,372.7	19,730,956.0	25.7
	ТАТВАРЫН ДАРААХ ЦЭВЭР АШИГ	29,834,669.3	36,360,633.1	6,525,963.8	21.9

ББСБ-уудын нийт орлого, зардлын үзүүлэлтүүдийг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна.

/График 11/



Өмнөх онтой харьцуулахад системийн хувьд нийт ашиг нэмэгдсэн нь ББСБ-уудын активын болоод тооны өсөлт тэдгээрийн үйл ажиллагааны үр ашиг нэмэгдэж байгаатай шууд холбоотой байна.

Тайлант жилд 276 ББСБ буюу нийт ББСБ-ын 73.0 хувь нь 40,505,117.0 мянган төгрөгийн ашигтай, 69 ББСБ буюу нийт ББСБ-уудын 18.3 хувь нь 4,144,483.8 мянган төгрөгийн алдагдалтай ажиллаж тэдгээрийн нийт цэвэр ашиг 36,360,633.1 мянган төгрөгт хүрсэн байна.

ЗУРГАА. БҮЛГИЙН САНХҮҮГИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Нийт ББСБ-уудыг активын хэмжээгээр нь 400,000.0 мянган төгрөг хүртэл активтай, 400,000.0 мянган төгрөгөөс 1.0 тэрбум төгрөг хүртэл активтай, 1.0 тэрбум төгрөгөөс 5.0 тэрбум төгрөг хүртэлх активтай, 5.0 тэрбум төгрөг ба түүнээс дээш төгрөгийн активтай ББСБ гэсэн 4 бүлэгт хуваан тооцов. 2014 оны жилийн эцсийн байдлаарх бүлгүүдийн бүтэц дараах байдалтай байна:

/Хүснэгт 16/

№	Бүлэг	Бүлэгт хамаарах ББСБ-ын тоо	Бүлгийн нийт актив		Нэмэлт мэдээлэл
			Актив /мянган төгрөг/	Нийт активт эзлэх хэмжээ /хувь/	
1	Бүлэг 01	20	257,307,496.5	50.65	5.0 тэрбум төгрөгнөөс дээш активтай
2	Бүлэг 02	72	137,243,375.9	27.02	1.0 тэрбумаас 5.0 тэрбум төгрөг хүртэлх активтай
3	Бүлэг 03	181	96,188,897.9	18.94	400,000.0 мянган төгрөгөөс 1.0 тэрбум төгрөг хүртэл хэмжээний активтай
4	Бүлэг 04	105	17,225,913.7	3.39	400,000.0 мянган төгрөг хүртэл хэмжээний активтай
НИЙТ		378	507,965,684.0	100.0	

2014 оны жилийн эцсийн байдлаарх бүлгүүдийн санхүүгийн голлох үзүүлэлтүүд дараах байдалтай байна.

/Хүснэгт 17/

№	Үзүүлэлтүүд	Бүлэг 01	Бүлэг 02	Бүлэг 03	Бүлэг 04	НИЙТ
1	Нийт актив /мянган төгрөг/	257,307,496.5	137,243,375.9	96,188,897.9	17,225,913.7	507,965,684.0
	ББСБ-уудын нийт активт эзлэх хувь	50.65	27.02	18.94	3.39	100.0
2	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөг/	154,978,498.1	87,496,406.4	55,142,882.2	5,515,072.7	303,132,859.4
	ББСБ-уудын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	51.13	28.86	18.19	1.82	100.0
3	Нийт өр төлбөр /мянган төгрөг/	140,162,174.1	31,326,272.3	4,156,268.2	243,123.7	175,887,838.3
	ББСБ-уудын нийт өр төлбөрт эзлэх хувь	79.69	17.81	2.36	0.14	100.0
4	Эзэмшигчдийн өмч /мянган төгрөг/	117,145,322.4	105,917,103.7	92,032,629.6	16,982,790.0	332,077,845.7
	ББСБ-уудын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь	35.28	31.90	27.71	5.11	100.0
5	Хувьцаат капитал /мянган төгрөг/	77,317,221.2	83,692,333.8	80,062,460.1	17,125,967.4	258,197,982.6

ББСБ-уудын нийт хувьцаат капиталд эзлэх хувь		29.94	32.41	31.01	6.63	100.0
6	Хуримтлагдсан ашиг, алдагдал /мянган төгрөг/	33,358,128.0	20,263,030.6	10,907,370.1	-500,010.5	64,028,518.3
Салбарын нийт хуримтлагдсан ашигт эзлэх хувь		52.10	31.65	17.04	-0.78	100.0
7	Тайлант үеийн цэвэр ашиг /мянган төгрөг/	16,570,956.1	14,136,968.4	6,107,842.4	-455,133.8	36,360,633.2
Салбарын нийт татварын дараах цэвэр ашигт эзлэх хувь		45.57	38.88	16.8	-1.25	100.0

2014 оны жилийн эцсийн байдлаар банк бус санхүүгийн тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй 378 ББСБ-ын 5,3 хувийг 5.0 тэрбумаас дээш актив хөрөнгөтэй 20 ББСБ эзэлж байгаа ба тэдгээр нь нийт ББСБ-уудын активын 50.6 хувь, зээлийн өрийн үлдэгдлийн 51.1 хувь, нийт өр төлбөрийн 79.7 хувь, эзэмшигчдийн өмчийн 35.3 хувь, хувь нийлүүлсэн хөрөнгийн 29.9 хувь, хуримтлагдсан ашгийн 52.1 хувь, тайлант хугацаанд үүссэн цэвэр ашгийн 45.6 хувийг тус тус эзэлж байна.

Харин нийт ББСБ-уудын 27.8 хувийг 400.0 сая төгрөг хүртэл актив хөрөнгөтэй 105 ББСБ эзэлж байгаа ба тэдгээр нь нийт ББСБ-уудын активын 3.4 хувь, зээлийн өрийн үлдэгдлийн 1.8 хувь, нийт өр төлбөрийн 0.1 хувь, эзэмшигчдийн өмчийн 5.1 хувь, хувь нийлүүлсэн хөрөнгийн 6.6 хувийг бүрдүүлж байна.

2014 оны жилийн эцэст салбарын хэмжээгээр 4,144,483.8 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан бөгөөд алдагдалтай ажилласан ББСБ-уудын судалгааг бүлэглэлтийн судалгаатай харьцуулахад алдагдалтай ажилласан ББСБ-уудын 55.1 хувийг 400.0 хүртэл сая төгрөгийн актив хөрөнгөтэй ББСБ-ууд эзэлж байх ба салбарын нийт алдагдал тухайн бүлэгт хамрагдаж байна.

ББСБ-уудыг бүлэглэсэн судалгаанаас харахад 5.0 тэрбум төгрөгөөс дээш актив хөрөнгөтэй үйл ажиллагаа явуулж буй 20 ББСБ нь тухайн салбарын санхүүгийн гол үзүүлэлтүүдийн 29.9-79.7 хувийг дангаараа бүрдүүлж байна.

ДОЛОО. САЛБАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

ББСБ-ын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр Хорооны 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон үзүүлэлтүүд системийн түвшинд дараах байдалтай байна. Үүнд:

- нийт өөрийн хөрөнгө 331,786,888.6 мянган төгрөг, эрсдэлээр жигнэсэн актив 350,294,274.7 мянган төгрөг байгаагаас өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны шалгуур үзүүлэлт нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын хувьд 93.7% хувь, өөрийн хөрөнгийн хувьд 96.7% хувь, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын хувьд 64.4 хувь;

- валютын дансны цэвэр зөрүү 12,165,149.1 мянган төгрөг, тухайн валютаарх өөрийн хөрөнгө 331,578,050.5 мянган төгрөг байгаагаас нийт гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа 3.67 хувь;

- итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн өглөгийн үлдэгдэл 25,659,100.7 мянган төгрөг, өөрийн хөрөнгө 340,531,102.3 мянган төгрөг байгаагаас итгэлцлийн үйлчилгээний өглөг, өөрийн хөрөнгийн харьцаа 7.54 хувь;

- түргэн борлогдох актив 122,036,939.4 мянган төгрөг, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө 123,366,059.2 мянган төгрөг байгаагаас төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 98.9 хувь;

- нийт цэвэршүүлсэн үндсэн хөрөнгө 8,512,818.1 мянган төгрөг, нийт актив 507,965,683.9 мянган төгрөг байгаагаас үндсэн хөрөнгө, нийт активын харьцаа 1.68% хувь байгаа нь зохистой харьцааны үзүүлэлтүүдийг тус тус ханган ажиллаж байна.

Харин активын эрсдэлийн санг 15,571,109.3 мянган төгрөгөөр байгуулбал зохихоос 555,272.4 мянган төгрөгөөр илүү буюу нийт 16,126,381.7 мянган төгрөгөөр байгуулсан байна.

Тайлант хугацаанд салбарын дүнгээр дээр дурьдсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг ханган ажиллаж байгаа боловч үйл ажиллагаа явуулж буй 378 ББСБ нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хэрхэн ханган ажилласан нь дараах байдалтай байна.

/Хүснэгт 18/

№	Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Нийт ББСБ-д эзлэх хувь
1	Зохистой харьцааг хангаж ажилласан ББСБ-ын тоо	49	13.0%
2	1 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	201	53.2%
3	2 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	107	28.3%
4	3 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	17	4.5%
5	4 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	2	0.5%
6	5 ба дээш зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	2	0.5%
	Нийт	378	100.0%

НАЙМ. ДҮГНЭЛТ

- 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэлд тайлан ирүүлбэл зохих нийт 378 ББСБ-аас 376 нь буюу 99.5 хувь нь тайлангаа ирүүлсэн ба 20 нь буюу 5.3 хувь нь эхлэлтийн санхүүгийн тайлангийн дүнгээр хамрагдсан байна.
- ББСБ-уудын голлох үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт актив 126,834,931.2 мянган төгрөг буюу 33.3 хувь, нийт зээлийн өрийн үлдэгдэл 79,421,145.5 мянган төгрөг буюу 35.5 хувь, эзэмшигчдийн өмч 97,739,893.1 мянган төгрөг буюу 41.7 хувь, нийт хувь нийлүүлсэн хөрөнгө 74,506,354.8 мянган төгрөг буюу 40.6 хувиар тус тус өссөн.
- ББСБ-уудын нийт актив 2014 оны жилийн эцсийн байдлаар 507,965,683.9 мянган төгрөг байгаа нь банкны салбарын нийт активтай харьцуулахад 2.3 хувь, нийт зээлийн өрийн үлдэгдэл 303,132,859.4 мянган төгрөг байгаа нь банкны салбарын нийт зээлтэй харьцуулахад 2.4 хувь, нийт хувь нийлүүлсэн хөрөнгө 258,197,982.6 мянган төгрөг байгаа нь банкны салбарын нийт хувь нийлүүлсэн хөрөнгөтэй харьцуулахад 65.6 хувьтай тус тус тэнцэж байна.
- Зээлийн мэдээллийн тухай хууль /9.1.7. банк, банк бус санхүүгийн байгууллага нь Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд шаардлагатай мэдээллийг өгөх, авах гэрээг байгуулж, мэдээлэл солилцох үүрэг хүлээх"-аар хуульчилсны дагуу тайлант улиралд нийт 183 ББСБ Монголбанкны зээлийн мэдээллийн сантай хамтран ажиллах гэрээ байгуулан, зээлдэгчийн талаарх мэдээлэл, лавлагааг зээлийн үйл ажиллагаандаа авч ашиглаж байгаа нь зээлийн үйл ажиллагаа эрхлэх 323 ББСБ-ын 56.7 хувийг эзэлж байна.
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон Хорооны 2009 оны 253 дугаар тогтоолоор баталсан "Харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам"-д заасны дагуу нийт ББСБ-ын 89.7 хувь буюу 339 нь "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод журам"-ыг батлан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, 97.6 хувь буюу 369 нь дээрх хуулийн хэрэгжилтийг хариуцах, байнгын хяналт тавих үүрэг бүхий ажилтныг томилон ажиллуулж байна.

6. 2014 онд 263 ББСБ-ын Хороонд төвлөрүүлбэл зохих нийт 258,782.0 мянган төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлс төлөгдөхөөс 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 257,735.0 мянган төгрөгийг Хорооны дансанд төвлөрүүлсэн нь 99.6 хувьтай байна.
7. Нийт 263 ББСБ нь Аудитын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хөндлөнгийн аудитаар баталгаажуулах үүрэг хүлээснээс 100.0 хувь буюу 263 ББСБ санхүүгийн тайлангаа аудитаар баталгаажуулан Хороонд ирүүлсэн.
8. Бичил санхүүгийн хөгжлийн сангаас дамжуулан зээлдүүлэх сонгон шалгаруулалтад 48 ББСБ-ын санхүүгийн үзүүлэлтүүдийн талаарх судалгаа хийгдсэн бөгөөд 2014 оны жилийн эцсийн байдлаар 12,502,932.8 мянган төгрөгийн төслийн зээлийн өрийн үлдэгдэлтэй байна.
9. Тайлант хугацаанд ББСБ-уудын дүнгээр активын өгөөж 7.2 хувь, ашигт ажиллагааны харьцаа 27.3 хувь, санхүүгийн тогтвортой байдлын харьцаа 53.0 хувь, нийт хөрөнгөнд эзлэх өрийн харьцаа 34.6 хувьтай байна

БИЧИЛ САНХҮҮГИЙН ГАЗАР